



ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 13

Мандалговь

Хөрөнгө дансанд бүртгэх
зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3-ын "б" заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. ЭДЦСургуулийн 3 нэрийн 3,873,164 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 1-р цэцэрлэгийн 4 нэрийн 1,179,000 төгрөгийн тавилга, эд хогшил, 3 нэрийн 1,490,000 төгрөгийн машин тоног төхөөрөмж, **нийт 2,669,000 төгрөг**, 3-р цэцэрлэгийн 1 нэрийн 6,600,000 төгрөгийн тавилга, эд хогшил, 5-р цэцэрлэгийн 1 нэрийн 9,955,000 төгрөгийн тавилга, эд хогшил, 6-р цэцэрлэгийн 1 нэрийн 8,360,000 төгрөгийн тавилга, эд хогшил, 7-р цэцэрлэгийн 1 нэрийн 8,360,000 төгрөгийн тавилга, эд хогшлыг тус тус байгууллагын дансанд бүртгэх зөвшөөрөл олгосугай.

2. Орлогодох хөрөнгийн холбогдох бичиг баримтын бүрдлийг журмын дагуу хангаж дансанд бүртгэхийг ЭДЦСургууль, 1,3,5,6,7-р цэцэрлэгийн нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг ЭДЦСургуулийн захирал, 1,3,5,6,7-р цэцэрлэгийн эрхлэгч, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга нарт даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ